



2025 оны 2-р сарын 20

**Хэвлэлийн мэдээ
АмЧам Монгол**

**“Нэн-чухал ашигт малтмал ба Монгол Улсын шилжилтэд нөлөөлөх чухал шийдвэрүүд”
сэдэвт хэлэлцүүлэг зохион байгуулав**



УЛААНБААТАР ХОТ, Монгол Улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхим (“АмЧам Монгол”) 2025 оны 2-р сарын 18-ны өдөр “Нэн-чухал ашигт малтмал ба Монгол Улсын шилжилтэд нөлөөлөх чухал шийдвэрүүд” сэдэвт хэлэлцүүлгийг зохион байгуулав.

АмЧам Монголын 2-р сарын ээлжит хэлэлцүүлэгт Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г. Намчинсүрэн, АНУ-ын Элчин сайдын яамны Худалдааны асуудал эрхэлсэн ахлах мэргэжилтэн Майкл Ричмонд, Олон улсын санхүүгийн корпорацийн суурин төлөөлөгч Мэтью Лэ Блан, Монголиан Нэшнл Рийр Ийрт Корп. ХХК-ийн гүйцэтгэх захирал А. Цолмон нар панелистаар оролцож, хэлэлцүүлгийг АмЧам-ын ТУЗ-ийн тэргүүн Рандольф Коппа удирдан явуулав.

Монгол Улсад байгаа цөөн тооны нэн-чухал эрдэс баялаг бүхий ордууд, тэдгээр дээр суурилсан хайгуул, олборлолтын шатны төслүүд хэрхэн хөгжиж буй талаар панелистууд байр сууриа илэрхийлэв.

“Монголиан Нэшнл Рийр Ийрт Корп” ХХК-ийн гүйцэтгэх захирал А. Цолмон “Халзан Бүрэгтэй төслийн эхний шатны өрөмдлөгийн ажил 2023 онд дууссан. 2024 онд урьдчилсан техник эдийн засгийн үндэслэлээ гаргаж, үргэлжлүүлэн өрөмдлөгийн ажлыг хийж, нарийвчилсан судалгаануудыг хийх шаардлагатай байна. Ордын насыг уртасгаж, улсдаа хуримтлуулах татварын дүн, ажлын байр шинээр бий болгох, эдийн засагт үр өгөөжөө өгөх зэрэг урт хугацаанд тогтвортой өсгөх зорилготойгоор ажиллаж байна” гэж онцлов.



Хэлэлцүүлгийн үеэр хууль эрх зүйн орчинд тодорхой ахиц гарч байгаа хэдий ч зарим төсөл хөгжүүлэлтэд тулгардаг бэрхшээлүүд, тухайлбал орон нутаг ба иргэдтэй харилцан ойлголцох байдал ярвигтай хэвээр байгаа тухай ярилцав. Нэр томъёо, ойлголтуудын зөрүүгээс үүдэлтэй маргаанууд, олон нийт, нийгэм рүү сөргөөр нөлөөлөх үзэгдэл буурахгүй байгаа нь аливаа төслийг урагшлуулахад хүндрэл учруулдаг болохыг тэмдэглэв.



Олон улсын харилцаа, гуравдагч хөршийн хамтын ажиллагааны хүрээнд АНУ, Монгол Улс чухал ач холбогдолтой ашигт малтмалын чиглэлээр хамтран ажиллах санамж бичигт 2023 оны 6-р сард гарын үсэг зурсан билээ. Энэхүү санамж бичиг нь Монгол Улсын эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулалт татах чадавхийг бэхжүүлэхэд дэмжлэг үзүүлэх техникийн чиглэлээр Монгол Улс, АНУ-ын хамтын ажиллагааны хүрээг тодорхойлсон. Мөн түүнчлэн, Орано групп болон Монгол Улсын

Засгийн газартай хийсэн хөрөнгө оруулалтын гэрээг 2025 оны 1-р сард үзэглэсэн нь ойрын жилүүдэд хийгдсэн томоохон ажлуудын нэг болсонг АмЧам Монгол онцоллоо.

Энэ удаагийн хэлэлцүүлэгт хүрэлцэн ирсэн гишүүн байгууллагуудын төлөөлөл болон зочдод идэвхтэй, ач холбогдолтой яриа өрнүүлсэнд талархал илэрхийлж байна.



Хэлэлцүүлгийн төгсгөлд АмЧам Монголын шинэ гишүүн “Pick Pack Group”-т баяр хүргэж, гишүүнчлэлийн сертификат гардуулав.

АмЧам Монголын тухай

АмЧам Монгол АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн Ази Номхон далайн 29 орны Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.